



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2015 оны 01 сарын 21 өдөр

Дугаар 43

Улаанбаатар хот

“Соёмбо даатгал” ХХК-д эрх бүхий албан  
тушаалтан томилохыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.3, Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.1, Даатгалын тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Соёмбо даатгал” ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн даргаар Чимид овогтой Батцогт, гишүүнээр Цэрэнчанаа овогтой Баттулга, Чимид овогтой Сайнзаяа, Оросоо овогтой Мэнджаргал, Баттогтох овогтой Ундарлаа нарыг тус тус томилохыг зөвшөөрсүгэй.

2. Хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж, даатгуулагчдын эрх ашгийг дээдлэн ажиллахыг Ч.Батцогт, Ц.Баттулга, Ч.Сайнзаяа, О.Мэнджаргал, Б.Ундарлаа нарт үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Ц.Энхбаяр/-нд даалгасугай.

ДАРГА



З.НАРАНТУЯА

008581